

БАТЛАВ.
“ЭЙБЛСОФТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ДАВААДОРЖ

БАТЛАВ.
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК- ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.МӨНХӨӨ

ЭЙБЛ СИСТЕМ ИЙН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2023 оны 03 дугаар
сарын 21-ны өдөр

№ АҮ-23/18

2023/16.

Улаанбаатар
хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү ашиглалт, үйлчилгээний гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г нэг талаас "Эйблсофт" ХХК-ийг (регистрийн дугаар: 5420342) төлөөлж Санхүүгийн мэргэжилтэн Ш.Лхамцэен (цаашид "Эйбл" гэх), нөгөө талаас Амгалан дулааны станц ТӨХК (регистрийн дугаар:6021646) төлөөлж Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-Очир (цаашид "үйлчлүүлэгч" гэх) нар (цаашид хамтад нь "талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Эйбл нь “Эйбл систем” (цаашид “систем” гэх) буюу гэрээний “Хавсралт 1”-т заасан програм, модулиудаар үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ, үйлчлүүлэгчийн систем ашиглалт болон тэдгээрийн төлбөрийг гэрээнд заасны дагуу Эйблд төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.3. Эйбл нь системтэй холбоотой, үйлчлүүлэгч нь системд буй түүний өгөгдөлд хамаарах бүх оюуны болон бусад өмчлөх эрхийг тус тус эзэмшинэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР


2.1. “Систем” гэдэг нь холбогдох техник орчин, сервер, тоног төхөөрөмж, үүлэн тооцоололд суурилсан програм хангамж зэргээс бүрдсэн, үйлчлүүлэгчийн удирдлагын болон дотоод үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хэрэглэгч хэрэглэх боломжтой төрөлжсөн програмуудын цогц үйл ажиллагааг хэлнэ.

2.2. “Программ” гэдэг нь системийн цогц үйл ажиллагааг хангах зорилготой түүнд агуулагдах тодорхой чиг үүрэг бүхий нэг эсвэл олон модулийн ажиллагааг хэлнэ.

2.3. “Модуль” гэдэг нь програмын ажиллагааг хангах зорилготой түүнд агуулагдах тодорхой үүрэгтэй дэд модуль, програмчлагдсан хэсгүүдийн ажиллагааг хэлнэ.

2.4. “Системийн удирдагч” гэдэг нь үйлчлүүлэгчийн хэрэглэгч нарт системийг хэрэглэх заавар, зөвлөгөө өгөх, системийн програм, модулиудыг бүхэлд нь удирдах эрхтэй, Эйблтэй тогтмол харилцах зорилгоор үйлчлүүлэгчээс томилсон давуу эрхтэй хэрэглэгчийг хэлнэ.


Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцаар хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

2.5. “Хэрэглэгч” гэдэг нь системд бүртгэлтэй, системийн програм, модулиудыг хандах эрхийн дагуу бүрэн хэрэглэх эрх олгосон үйлчлүүлэгчийн ажилтан, албан хаагчийг хэлнэ.

2.6. “Өгөгдөл” гэдэг нь хэрэглэгчийн системд дамжуулсан бичиглэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад зүйлийг хэлнэ.

2.7. “Нууцлал, аюулгүй байдал” гэдэг нь үйлчлүүлэгчийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийг гадны буюу гуравдагч этгээдэд алдахгүйн тулд Эйбл болон үйлчлүүлэгчийн зүгээс нууцлалын талаар гэрээгээр хүлээсэн үүргийг хэлнэ.

2.8. “Сайжруулалт” гэдэг нь Эйблээс үйлчлүүлэгч эсвэл хэрэглэгчид зориулан програм, модуль шинээр гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг ажил гүйцэтгэхийг хэлнэ.

2.9. “Засвар” гэдэг нь системийн програм, модулийн ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн доголдуулах ямар нэг алдааг Эйблд мэдэгдсэн эсвэл мэдсэн даруйд гэрээний “Хавсралт 3”-т зааснаар засварлаж хэвийн ажиллагаанд оруулахыг хэлнэ.

2.10. “Ашиглалт” гэдэг нь системийг хэрэглэж буй үйлчлүүлэгчийн нийт хэрэглэгчийн гэрээний хугацаан дахь хэрэглээг хэлнэ.

2.11. “Үйлчилгээ” гэдэг нь үйлчлүүлэгч системийг хэвийн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Эйблээс хэрэгжүүлэх дараах үйл ажиллагаануудыг хэлнэ. Үүнд: Системийн нууцлал аюулгүй байдлыг хангах, үйлчлүүлэгчээс санал, хүсэлт хүлээн авах, мэдээллээр хангах, сайжруулалт, засвар хийх.

2.12. “Сургалт” гэдэг нь Эйблээс үйлчлүүлэгч болон хэрэглэгчдэд системийн тухай түүний хэрэглээний талаар заах, түүнийг бие дааж хэрэглэх чадвартай болгох үйл ажиллагаа юм. Сургалт зөвхөн нэвтрүүлэлтийн хугацаанд үнэ төлбөргүй байна. Сургалтыг Эйблийн зөвшөөрөлтэйгээр хувь хүн болон хуулийн этгээд зохион байгуулж болно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ

3.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.


3.2. Гэрээний хугацаа дуусгавар болохоос 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө талуудын аль нэг нь гэрээг өөрчлөх, цуцлах саналыг нөгөө талдаа бичгээр гаргаагүй тохиолдолд гэрээ дахин 1 (нэг) жилээр сунгагдсанд тооцогдох ба цаашид энэ тохиолдолд жил бүр гэрээ сунгагдана.

3.3. Гэрээний хугацаа дуусгавар болж үйлчлүүлэгч төлбөрөө төлөөгүйн улмаас тооцох нийт алданги гэрээний 4.7-д заасан хувь хэмжээнд хүрвэл Эйбл уг төлбөр, алдангийг барагдуулах хүртэлх хугацаанд системийг түр эсвэл бүр мөсөн хааж болно.


3.4. Талуудын аль нэг нь дангаараа гэрээг цуцлах эрхгүй бөгөөд дор дурдсан тохиолдолд гэрээг цуцална. Үүнд:

3.4.1. талууд харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно

3.4.2. талуудын аль нэг нь дампуурсан, татан буугдсан болон төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууц мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

3.4.3. талуудын аль нэг нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн ба зөрчлийг арилгах нэмэлт хугацааг талууд харилцан тохиролцож тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал дангаараа гэрээг цуцлах эрхтэй бөгөөд учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй

ДӨРӨВ. АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

4.1. Системийн ашиглалт, үйлчилгээний 1 (нэг) жилийн төлбөрийг талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 10 өдөрт, гэрээ 1 (нэг) жилээр шууд сунгагдсанд тооцсон тохиолдолд Эйблээс үйлчлүүлэгчид ирүүлсэн нэхэмжлэл дээр бичигдсэн огнооноос хойш ажлын 15 өдөрт багтаан 4.1.1-т заасан дансанд шилжүүлнэ.

4.1.1. Хас банк: “Эйбл Софт” ХХК-ийн төгрөгийн 5001867166 тоот данс

4.2. Үйлчлүүлэгчийн хэрэглэгчийн тооны хязгаар 17 (арван долоо) байна. Гэрээний хугацаанд үйлчлүүлэгчийн хүсэлтээр хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд нэг хэрэглэгчийн төлбөр 120,000 (нэг зуун хорин мянга)-н төгрөг байна.

4.3. Системийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг нэг хэрэглэгчийн хувьд жил бүр 90,000 (ерэн мянга)-н төгрөгөөр тооцно.

4.4. Өгөгдөл байршуулах төлбөр 50гб өгөгдөл хадгалахаар тооцож жил бүр 1,200,000 (нэг зуун мянга)-н төгрөг байна. Хэрэв өгөгдөл байршуулах талбарын хэмжээг нэмэгдүүлэх бол үйлчлүүлэгчийн хүсэлтээр “Хавсралт 4”-т тусгагдсан хэмжээгээр төлбөр төлнө.

4.5. Системийн ашиглалт, үйлчилгээний жилийн төлбөр нь 1,530,000 (нэг сая таван зуун гучин мянган) төгрөг, өгөгдөл байршуулалтын жилийн төлбөр 1,200,000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөг нийт жилийн төлбөр 2,730,000 (хоёр сая долоон зуун гучин мянга)-н төгрөг байна. Үнийн дүнд “Нэмэгдсэн өртгийн албан татвар” орсон болно.

4.6. Үйлчлүүлэгч төлбөрийг хугацаандаа шилжүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги төлнө. Алдангийн хэмжээ нийт төлөх үнийн дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй.

ТАВ. ЭЙБЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Эйбл дор дурдсан эрхтэй:

5.1.1. үйлчлүүлэгчээс төлбөрөө төлөхийг шаардах, төлөгдөөгүй үнийн дүнгээс гэрээнд заасны дагуу алданги тооцож нэхэмжлэх


5.1.2. үйлчлүүлэгчийн нэр, барааны тэмдгийг үйлчлүүлэгч, дэмжигч, хамтран ажиллагч зэргээр ашиглах

5.1.3. үйлчлүүлэгчийн зөвхөн өөртөө зориулж хийлгэхээр санал болгосон төлбөртэй эсвэл төлбөргүй сайжруулалт хийлгэхээс татгалзах


5.1.4. өгөгдлийг үйлчилгээ үзүүлэх зорилгоор хадгалах, зөөвөрлөх, архивлах, зэргээр ашиглах

5.1.5. сайжруулалт хийх

5.2. Эйбл дор дурдсан үүрэг хүлээнэ:



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууц мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.


- 5.2.1. системийг “Хавсралт 2”-г заасан хуваарийн дагуу нэвтрүүлэх
- 5.2.2. системд гарсан алдаа доголдлыг гэрээний “Хавсралт 3”-г заасны дагуу цаг алдалгүй засварлах
- 5.2.3. хэрэглэгчид зориулж системийг ашиглахтай холбоотой онлайн (*online*) гарын авлага материалаар хангах
- 5.2.4. сайжруулалттай холбоотой мэдээлэл, сургалт, зааварчилгааг системийн удирдагчид тухай бүр өгөх
- 5.2.5. систем болон өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс өөрөөс шалтгаалах урьдчилсан хамгаалалт (SSL, Firewall)-ыг бүрэн хийсэн байх
- 5.2.6. өгөгдлийг үйлчлүүлэгчийн цахим архивт жил бүр хүлээлгэн өгөх
- 5.2.7. үйлчлүүлэгчийн хүсэлтээр системийг хэрэглэх тухай нэмэлт сургалт, зааварчилгааг талууд үнэ тохиролцсоны дагуу хийх
- 5.2.8. гэрээний 6.2.5-д заасан зөрчил гарсан тухай мэдэгдэл хүлээн авсан даруйд хууль бус материалыг цаг алдалгүй устгах
- 5.2.9. системд саатал, доголдол гарсан тохиолдолд түүнийг хэвийн ажиллагаанд оруулах үүднээс урьдчилан сануулалгүйгээр ажиллагааг хэсэгчлэн болон бүхлээр нь хязгаарлах, засварлах ба энэ нь системийн ажиллагааг дордуулахгүй байх
- 5.2.10. Үйлчлүүлэгч байгууллагын мэдээллийн аюулгүй байдал болон мэдээллийн нууцыг чанд хадгалах

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Үйлчлүүлэгч дор дурдсан эрхтэй:

- 6.1.1. Эйблд мэдэгдсэн системийн алдаа, доголдлыг гэрээний “Хавсралт 3”-г заасны дагуу засварлахыг шаардах
- 6.1.2. Эйблийн сайжруулалтын үр дүнд гэрээний “Хавсралт 1”-г зааснаас өөр програм, модуль шинээр гаргахад түүнийг хэрэглэхгүйгээр татгалзах
- 6.1.3. Эйблээс жил бүр өгөгдлийг цахим архивтаа хүлээн авах
- 6.1.4. Эйбл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах санал гаргах
- 6.1.5. Нэмэлт хэрэглэгч холбох асуудлыг үйлчлүүлэгч тал буюу Захиргаа удирдлагын хэлтсийн даргын зөвшөөрлөөр холбоно. Бусад тохиолдолд хориглоно.
- 6.1.6. Ажлаас гарсан, чөлөөлөгдсөн ажилтны программ руу нэвтрэх эрхийг хаах тухай асуудлыг үйлчлүүлэгч тал буюу Захиргаа удирдлагын хэлтсийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

6.2. Үйлчлүүлэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцаг, замаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах нийтийн хүртээл болгохыг хориглоно.

- 6.2.1. системийг “Хавсралт 2”-г заасан хуваарийн дагуу нэвтрүүлэх
- 6.2.2. төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх
- 6.2.3. системийн зохиогчийн эрхтэй холбоотой зүйлсийг гуравдагч этгээдэд алдахгүй байх
- 6.2.4. өгөгдлийн үнэн зөв, хууль ёсны буюу ямар нэг хувь хүн, албан байгууллагын эрх, өмчид халдаагүй, төрийн нууцад хамаарахгүй байхыг хариуцах
- 6.2.5. хэрэглэгчийн нэр, нууц үг, өгөгдлийг хууль бусаар ашиглах, хэрэглэгчийн эрхгүй хүн системд нэвтрэх, хэрэглэх оролдлогуудыг хийлгэхгүй байх
- 6.2.6. системийг ашиг олох зорилгоор хэрэглэх, хувилах, дамлан зарах, эх кодыг бүхлээр нь буюу хэсэгчлэн ашиглах, системтэй холбоотой оюуны өмчийн тэмдэглэлүүдийг устгах, гуйвуулах үйлдэл хийхгүй байх
- 6.2.7. системийн нууцлал, аюулгүй ажиллагааны горимыг задруулах, тасалдуулах, өгөгдлийг замаас нь унших оролдлого хийхгүй байх
- 6.2.8. системд ачаалал үүсгэж болох томоохон хэмжээний өгөгдөл, вирус, бусад аюултай програмыг серверт дамжуулахгүй байх
- 6.2.9. хэрэглэгч эсвэл түүний нэр, нууц үгээр нэвтэрсэн хүн энэхүү гэрээний 6.2.3-өөс 6.2.8-д заасан үүргийг хүлээх ёстой бөгөөд үүнийг үйлчлүүлэгч батлан даах

ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

7.1. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан хохирлыг гэм буруутай тал нь энэ гэрээ болон хууль тогтоомжийн дагуу нотлогдсон хэмжээгээр бүрэн барагдуулах үүрэг хүлээнэ.

7.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл, нөгөө талтайгаа зөрчлийг арилгах хугацаа болон арга замыг тохиролцож, зөрчлийг уг тохиролцсон хугацаанд арилгаж учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

7.3. Эйблээс шалтгаалж систем нэвтрүүлэх хугацаа 7-оос дээш хоног хэтэрсэн тохиолдолд Эйбл хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 хувийн алдангийг Үйлчлүүлэгчид төлнө.


7.4. Үйлчлүүлэгчээс шалтгаалж систем нэвтрүүлэх хугацаа 7-оос дээш хоног хэтэрсэн тохиолдолд үйлчлүүлэгч хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 хувийн алдангийг Эйблд төлнө.

7.5. Гэрээний хугацаа дуусгавар болсон нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс хүлээсэн хохирлын төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

7.6. Энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралт, гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хүлээсэн үүргийг зөрчвөл энэхүү гэрээг зөрчсөнтэй нэгэн адил тооцно.



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно

7.7. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл 3 хоногийн дотор нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшилно.

7.7.1. гэнэтийн хүчин зүйл гэдэгт: Нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, хорио цээр, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэргийг ойлгоно

7.7.2. давагдашгүй хүчин зүйл гэдэгт: Гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг даван туулах боломжгүй байгалийн гамшгийг хамааруулан ойлгоно

7.8. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

7.9. Гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш үйлчлүүлэгчийн өгөгдлийг Эйбл гурван сар хадгалах үүрэг хүлээнэ. Энэ хугацаанд үйлчлүүлэгч өөрийн өгөгдлийг авах үүрэгтэй ба түүнээс цааши хугацаанд тус өгөгдөл системээс автоматаар устгагдана. Үйлчлүүлэгч өөрийн өгөгдлийг аваагүйгээс үүдэх асуудалд Эйбл хариуцлага хүлээхгүй.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1. Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

8.2. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.


8.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

8.4. Талууд гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай мэдээ, мэдээллийг задруулахгүй.

8.5. Талууд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэхийг хориглоно. Эрх, үүргээ зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэнтэй холбоотойгоор нөгөө талд учруулсан хохирлыг буруутай тал нь бүрэн хариуцна.



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно

ЕС. ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

ЭЙБЛСОФТ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 26, Сүхбаатарын гудамж, Пийс Бьюлдинг, 6 давхар

Утас: 11-310752

11-310757

И-мэйл: info@able.mn

Вэб: www.able.mn

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХЖ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1 тоот өөрийн байр

Утас: 77111252

Факс: 77111253


И-мэйл: amgalan@ahp.energy.mn

Вэб: ahp.energy.mn

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЭЙБЛИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Үйл ажиллагаа хариуцсан захирал

 Г.Оюунцацрал

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗУХ-ийн дарга

 Б.Ган-Очир

Эдийн засагч

 Ө.Удвал

Системийн удирдагч (админ)-аар томилогдсон, Эйблтэй холбогдож ажиллах ажилтан

ТУСПИ

 А.Батзаяа

Ажлын утас: 77111255

Гар утас: 99063759

И-мэйл: a.batzaya@amgalantplant.mn



Талуудын гарын үсэг




Энэхүү гэрээ нь байгууллагын нүүдэд хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

ЭЙБЛЭЭС ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД НИЙЛҮҮЛЭХ
СИСТЕМИЙН ПРОГРАММ, МОДУЛИУД

Хүснэгт 1

Программын төрлүүд	№	Системийн		Товч тайлбар
		програм	модуль	
Үндсэн програмууд	1	Хүний нөөц		байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаал, ажилтны бүртгэл удирдлагын програм
	2	Ажил хэрэг		ажилтны өдөр тутмын болон урт хугацааны албан, хувийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлан
	3	Захидал		дотоод болон гадаад холболттой хувийн захидал харилцааны програм
	4	Албан хэрэг хөтлөлт	Ирсэн бичиг	харьяа хэлтэс, байгууллагууд хоорондын цаасгүйгээр бичгээр харилцах, түүний онлайн шийдвэрлэлт
			Явсан бичиг	өргөдөл, гомдлын бүртгэл хөтлөлт, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайлан мэдээ бэлтгэх
			Өргөдөл гомдол	бийдвэрлэлтэд хяналт тавих, тайлан мэдээ бэлтгэх
			Бичиг төлөвлөлт	бичиг төлөвлөх, хянах, засварлах, илгээх
	5	Цаг бүртгэл		нүүр царай, хурууны хээ мэдрэгч төхөөрөмжтэй бүрэн холбогдож ажиллана
	6	Хурал		ээлжит болон ээлжит бус хурлын төлөвлөлт, хөтлөлт
	7	Олон нийт	Зар мэдээ	зар мэдээ тараах, сэтгэгдэл хөтлөх (нэмэх, засах, устгах) функцтэй
Хэлэлцүүлэг			хэлэлцүүлэг өрнүүлэх, түүнд сэтгэгдэл хөтлөх	
Санал асуулга			нээлттэй болон нууц мөн хэрэглэгчийн хязгаарлалттай санал асуулга явуулах	
Файлын сан			байгууллага дотроо, зөвхөн өөртөө, хязгаарлалттай хандахаар чухал хэрэгтэй файлаа хадгалах	
Зургийн цомог			зураг оруулах, сэтгэгдэл хөтлөх	
Урамшуулалт програмууд	1	Тушаал шийдвэр		дээд газраас ирсэн болон дотоод тушаал, шийдвэр
	2	Гэрээний бүртгэл		гэрээний бүртгэл, хяналт, хайлт хийх
	3	Нэрийн хуудас		нэрийн хуудасны цахим цуглуулга
	4	Үгийн сан		гадаад үг цээжлэх, түүгээрээ шалгалт өгч сорих
	5	Дотоод мессенжер		чатлах
	6	Масс мессеж		олон хүнд зэрэг мессеж илгээх функц
	7	Мэдээлэгч		системийн мэдээлэгч функц /notification/
	8	Мобайл програм		ухаалаг гар утаснаас системийг хэрэглэх /apps/



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууц мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ХУВААРЬ

Үйлчлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу урьдчилгаа төлбөрийг Эйблийн дансанд шилжүүлэн төлсөн өдрөөс эхлэн талууд доорх хуваарийн дагуу хамтран ажиллаж үйлчлүүлэгч талд системийг нэвтрүүлнэ.

Хүснэгт 2

№	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Үргэлжлэх хугацаа	Нэвтрүүлэлтийн хүрээнд хийгдэх ажлууд	Хариуцагч
1	Системийг суурилуулах	Ажлын 1 өдөр	Системийг Эйблийн серверт суурилуулж бүх тохиргоог хийнэ.	Эйбл
2	Системийн удирдагч, хүний нөөцийн ажилтанд сургалт явуулах	Ажлын 1 өдөр	Системийг цаашид хөтлөн удирдахад анхаарах зүйлс, хүний нөөцийн програмыг ашиглах, тохиргоо хэрхэн хийх талаар тусгай сургалт явуулна.	Эйбл
3	Бүх ажилтны системд нэвтрэх эрх үүсгэх	Ажлын 3 өдөр	Байгууллагын ажилтнуудын мэдээллийг иж бүрэн оруулж, бүх салбар нэгж, газар, албан тушаал, удирдлагын бүтцийг тодорхойлно.	Үйлчлүүлэгч
4	Ажилтнуудад биеэ дааж системтэй танилцах боломж олгох	Ажлын 10 өдөр	Бүх ажилтныг системд нэвтрэн орж түүний ерөнхий бүтэц, ажиллах зарчимтай танилцан бүрэлдэхүүн програмуудыг хэрэглэж үзсэн байхыг шаардана.	Үйлчлүүлэгч
5	Програмууд (албан бичиг, цаг бүртгэл, хурал)-ын хөтлөн удирдагч нарт сургалт хийх	Ажлын 1 өдөр	Програмуудыг цаашид хөтлөн ажиллуулахаар томилогдсон ажилчдад тус тусын хариуцсан програмыг ашиглах, тохиргоо хэрхэн хийх талаар тусгай сургалт явуулна.	Эйбл
6	Системийг хэрхэн ашиглах талаар бүх нийтийн сургалт явуулах	Ажлын 1-2 өдөр	Хуваарийн 3, 4-т заасан ажлууд заавал хийгдсэний дараа нийт хэрэглэгчдэд системийн ерөнхий бүтэц, ажиллах зарчим, бүрэлдэхүүн програмуудыг хэрхэн ашиглах тухай нэгдсэн сургалт явуулна.	Талууд хамтран
7	Систем нэвтрүүлэлтийг хаах	Ажлын 5 өдөр	Талууд нэвтрүүлэлт хийж хүлээлцсэн акт үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулна.	Талууд хамтран
8	Системийг үр ашигтай хэрэглэх журам батлах	-	Нийт хэрэглэгчдэд зориулсан тус системийг үр ашигтай хэрэглэх журам боловсруулж батлан үйл ажиллагаандаа мөрдөж болно.	Үйлчлүүлэгч

Жич: Дээрх ажлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр зэрэг эсвэл дарааллын хувьд өөрчлөн гүйцэтгээж болно.



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ЭЙБЛЭЭС ЗӨВЛӨМЖ АВАХ,
АЛДАА, ДОГОЛДОЛ БҮРТГҮҮЛЭХ,
ТҮҮНИЙГ ЗАСВАРЛАХ ТУХАЙ

Үйлчлүүлэгч нь утас, и-мэйл, онлайн чат, фэйсбүүк болон твиттер хуудсаар зөвлөгөө авах боломжтой. Эйблтэй холбогдсон хэрэглэгч нь нэр болон хувийн мэдээллээ өгөх ёстой бөгөөд Эйблийн зүгээс тохиолдол тус бүрийг бүртгэж асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлно.

Цагийн хуваарь: Эйблийн утас болон онлайн туслах долоо хоногийн Даваа - Баасан гаригт 08:00-17:00 цагийн хооронд ажиллана (утас: 310752, 310757, и-мэйл: info@able.mn).

Талуудын хамтын ажиллагаа: Эйблийн инженерүүд нь гарсан алдаа, доголдлыг засахын тулд шинжилж үзэх хэрэгтэй бөгөөд үйлчлүүлэгч нь инженерүүдийг холбогдох мэдээллээр хангаж дэмжиж ажиллах үүрэгтэй.

Алдааны зэрэглэл: Эйбл системд гарсан алдаа, доголдлыг дараах байдлаар зэрэглэн ангилж шаардлагатай арга хэмжээг авна.

Хүснэгт 3

Алдааны зэрэглэл	Тодорхойлолт буюу тайлбар
A1-р зэрэг (Нэн яаралтай)	Хэрэглэгчдийн дийлэнх нь системд нэвтрэх боломжгүй болсон
A2-р зэрэг (Яаралтай)	Системд нэвтрэх боломжтой боловч нэг эсвэл олон програм, модулийн түвшний ажиллагаа хэрэглэх боломжгүйгээр доголдсон
A3-р зэрэг (Энгийн)	Програм, модулийн түвшний ажиллагаа хэвийн биш боловч хэрэглэгчийн хэрэгцээг тодорхой хэмжээгээр хангаж байгаа

Засвар үйлчилгээ хийгдэх хугацаа: Эйбл алдаа, доголдлын зэрэглэлээс хамаарч засвар үйлчилгээг эхлүүлэх хугацааг дараах байдлаар тодорхойлж үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

Хүснэгт 4

Алдааны зэрэглэл	Эйблээс хариу мэдэгдэх хугацаа
A1-р зэрэг (Нэн яаралтай)	Мэдээлэл хүлээн авснаас хойш дараагийн ажлын өдөрт багтаж
A2-р зэрэг (Яаралтай)	Мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаж
A3-р зэрэг (Энгийн)	Мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаж

 Талуудын гарын үсэг 
Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тгараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.



ЭЙБЛ СИСТЕМИЙН НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

Хүснэгт 5

№	Нэмэлт төлбөртэй үйлчилгээ /байгууллага/	Төлбөр /төг/	
		1 удаа	Жилд
1	Суурилуулалт /1 удаа/	Эйблийн серверт 500 000₮	-
		Үйлчлүүлэгчийн серверт 1 000 000₮	-
2	Өгөгдөл байршуулах	50 гб өгөгдөл	100 000₮
		100 гб өгөгдөл	180 000₮
		200 гб өгөгдөл	320 000₮
		300 гб өгөгдөл	450 000₮
		500 гб өгөгдөл	700 000₮
3	Сургалт /нэмэлт, захиалгат/	1 тб өгөгдөл	1 250 000₮
		1 хүн цаг	5 000₮

Тайлбар:


100 ажилтантай байгууллага Эйбл системийн үйлчилгээг авахын тулд эхний жилд дараах төлбөрийг төлнө.

1. Лиценз	$17 \times 90,000 = 1,530,000₮$
2. Өгөгдөл /50гб/	$12 \times 100,000 = 1,200,000₮$
Нийт дүн	2,730,000 төг

Нэвтрүүлэлтийн болон нэмэлт сургалт авах, өөрийн сервер дээр Эйбл системийг суурилуулж хэрэглэх, илүү их өгөгдөл байршуулах хэрэгцээтэй болбол нэмэлт үйлчилгээнээс сонгоод хэрэглэх боломжтой.



Талуудын гарын үсэг



Энэхүү гэрээ нь байгууллагын нууцаг, хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно